



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/46/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25, № 01/123,
танай -ны № -т

БАТСҮМБЭР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА С.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оныг "Ногоон хөгжил-Баялаг бүтээгчдийг дэмжих жил" болгон зарлаж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 5 км урттай түймрийн халз зурвас татах ажлыг гүйцэтгэн, 13 урамшуулалт морин эргүүл, 8 байгаль хамгаалагч, 43 ойн нөхөрлөлийн гишүүдийг хяналтаар ажиллуулж, тайлант онд 78 га-д ойжуулалт хийжээ. "Тэрбум мод" тарих үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих зэрэг ажлын хүрээнд засмал зам дагуу 5 нэр төрлийн 130 орчим ширхэг мод тарьсан байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Тайлант оны батлагдсан зардлын төсвийг 48,599.4 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн ба цалин, нэмэгдэл урамшууллын болон орон нутгийн хөрөнгийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой, зарцуулаагүй үлдэгдэл 76,182.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, шинэ тамгын газар, баг, гэрэлт цамхаг, худаг, услалтын систем зэрэг 7 объектын гэрчилгээжсэн газрыг 378,086.0 мянган төгрөгөөр бүртгэж тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,706,452.05	73,848,023.41
33	АВЛАГА	2,000,000.00	2,078,653.51
33500	Бусад авлага	2,000,000.00	2,078,653.51
33510	Байгууллагаас авах авлага	0	78,653.51
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,000,000.00	2,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,706,452.05	62,769,369.90
35400	Хангамжийн материал	58,706,452.05	62,769,369.90
35410	Бичиг хэргийн материал	1,447,983.00	1,748,917.00
35420	Аж ахуйн материал	1,029,400.00	533,500.00
35440	Түлш, шатах тослох материал	3,665,090.05	3,086,108.90
35450	Барилгын засварын материал	2,161,900.00	1,157,600.00
35460	Хүнсний материал	16,196,470.00	13,227,975.00
35470	Бусад хангамжийн материал	34,205,609.00	43,015,269.00
36	НӨӨЦИЙН БАРАА	9,000,000.00	9,000,000.00
36300	Тэжээлийн нөөц	9,000,000.00	9,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,208,012,403.79	1,998,825,236.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,208,012,403.79	1,998,825,236.92
39200	Биет хөрөнгө	1,018,445,348.11	1,446,429,181.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,032,318,182.49	1,141,715,384.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	-226,436,155.48	-264,272,688.11
39203	Авто-тээврийн хэрэгсэл	183,599,555.00	344,430,278.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-153,105,360.18	-187,096,172.83
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	100,148,235.12	211,485,640.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-68,623,665.24	-63,566,859.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,216,117.10	78,496,117.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,613,033.60	-58,208,937.73
39209	Зам, гүүрийн байгууламж	1,063,506,328.00	1,063,506,328.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,052,442,944.68	-1,054,545,548.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	221,210,529.00	370,819,838.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-106,375,839.42	-137,377,597.23
39217	Ном	1,043,400.00	1,043,400.00
39300	Биет бус хөрөнгө	189,567,055.68	552,396,055.48
39301	Програм хангамж	1,645,000.00	1,645,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-989,444.48	-1,196,944.52
39303	Бусад биет бус хөрөнгө	199,170,000.00	577,256,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-10,258,499.84	-25,308,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,277,718,855.84	2,072,673,260.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,277,718,855.84	2,072,673,260.33
51	Засгийн газрын хувь оролцоо	1,277,718,855.84	2,072,673,260.33
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,009,750,503.06	1,009,750,503.06
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,009,750,503.06	1,009,750,503.06
51200	Хуримтлагдсан үр дүн	41,060,943.95	836,015,348.44
51210	Өмнөх үеийн үр дүн	103,045,287.41	41,060,943.95
51220	Тайлант үеийн үр дүн	-61,984,343.46	794,954,404.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	226,907,408.83	226,907,408.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,277,718,855.84	2,072,673,260.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	667,985,186.00	1,636,019,606.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,820,717.00	987,101,489.18
120	Нийтлэг татварын бус орлого	25,820,717.00	987,101,489.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,012,527.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,012,527.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,000,000.00	983,362,489.18
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	22,808,190.00	3,739,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	642,164,469.00	648,918,117.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,630,769.00	95,397,817.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	7,200,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	26,694,569.00	6,507,602.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	14,736,200.00	88,890,215.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	593,533,700.00	553,520,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	593,533,700.00	553,520,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	727,796,662.85	801,263,011.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	707,816,662.85	801,263,011.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	614,719,542.97	714,571,618.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,441,674.00	203,740,682.00
210101	Үндсэн цалин	181,644,345.00	157,741,844.00
210102	Нэмэгдэл	37,461,816.40	32,158,689.00
210104	Урамшуулал	0	13,840,149.00
210105	Гэрээт ажлын хөлс	44,335,512.60	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,215,962.12	26,811,307.32
210201	Тэтгэврийн даатгал	24,210,441.70	18,663,825.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,599,510.59	2,100,863.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,074,811.19	1,657,169.26
210204	Ажилгүйдлийн даатгал	483,314.16	397,256.83
210205	Эрүүл мэндийн даатгал	4,847,884.48	3,992,191.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,407,918.00	49,892,356.15
210301	Гэрэл, цахилгаан	12,029,575.00	9,382,744.00
210302	Түлш, халаалт	37,378,343.00	40,509,612.15
2104	Хангамж, бараа материалын зардал	46,177,736.25	62,664,211.74
210401	Бичиг хэрэг	2,919,619.00	5,293,086.00
210402	Тээвэр, шатахуун	8,969,570.00	11,515,303.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,302,370.00	1,244,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,333,769.25	43,346,882.74
210408	Бараа материал акталсны зардал	2,652,408.00	1,264,340.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,690,100.00	4,420,600.00
210604	Урсгал засвар	6,690,100.00	4,420,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,608,000.00	3,928,900.00
210702	Дотоод албан томилолт	1,608,000.00	3,928,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	2,929,398.00	67,676,369.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	1,803,338.00	66,347,084.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	309,700.00	245,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	353,360.00	365,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	143,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,248,754.60	295,437,191.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,843,142.75	134,075,025.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	105,275,611.85	161,362,166.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,097,119.88	86,691,392.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,276,056.00	10,509,247.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,807,400.00	9,852,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,468,656.00	656,547.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	61,821,063.88	76,182,145.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,821,063.88	76,182,145.97
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,980,000.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	19,980,000.00	0
221001	Их засвар	19,980,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-59,811,476.85	834,756,594.27
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,172,866.61	39,802,189.78
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	2,172,866.61	39,802,189.78
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-61,984,343.46	794,954,404.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	644,176,996.00	648,918,117.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	644,176,996.00	648,918,117.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,643,296.00	95,397,817.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	28,707,096.00	6,507,602.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	21,936,200.00	88,890,215.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	593,533,700.00	553,520,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	593,533,700.00	553,520,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	584,102,589.00	640,303,417.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584,102,589.00	640,303,417.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489,912,969.12	553,274,524.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,441,674.00	203,740,682.00
210101	Үндсэн цалин	181,644,345.00	157,741,844.00
210102	Нэмэгдэл	37,461,816.40	32,158,689.00
210104	Урамшуулал	0	13,840,149.00
210105	Гэрээт ажлын хөлс	44,335,512.60	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,215,962.12	26,811,307.32
210201	Тэтгэврийн даатгал	24,210,441.70	18,663,825.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,599,510.59	2,100,863.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,074,811.19	1,657,169.26
210204	Ажилгүйдлийн даатгал	483,314.16	397,256.83
210205	Эрүүл мэндийн даатгал	4,847,884.48	3,992,191.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,437,338.00	49,401,975.00
210301	Гэрэл, цахилгаан	12,329,575.00	13,868,071.00
210302	Түлш, халаалт	38,107,763.00	35,533,904.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,809,828.00	55,019,777.71
210401	Бичиг хэрэг	2,517,300.00	1,198,800.00
210402	Тээвэр, шатахуун	9,286,933.00	11,420,978.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,199,650.00	1,200,000.00
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,805,945.00	41,199,999.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,608,000.00	2,988,700.00
210702	Дотоод албан томилолт	1,608,000.00	2,988,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,193,558.00	69,186,306.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,067,498.00	68,113,021.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	309,700.00	254,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	353,360.00	356,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	143,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,706,609.00	144,625,776.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,706,609.00	144,625,776.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,189,619.88	87,028,892.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,368,556.00	10,846,747.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,368,656.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,807,400.00	9,852,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,192,500.00	994,047.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	61,821,063.88	76,182,145.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,821,063.88	76,182,145.97
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	60,074,407.00	8,614,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	60,074,407.00	8,614,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,074,407.00	8,614,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	60,074,407.00	8,614,700.00
222001	Тоног төхөөрөмж	19,980,000.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,094,407.00	8,614,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-60,074,407.00	-8,614,700.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	103,045,287.41	1,339,703,199.30
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	103,045,287.41	1,339,703,199.30
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-61,984,343.46	-61,984,343.46
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	41,060,943.95	1,277,718,855.84
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	41,060,943.95	1,277,718,855.84
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	41,060,943.95	1,277,718,855.84
19	Тайлант үеийн үр дүн	0	0	794,954,404.49	794,954,404.49
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,009,750,503.06	226,907,408.83	836,015,348.44	2,072,673,260.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	602,119,700.00	477,338,154.03	124,781,545.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,119,700.00	477,338,154.03	74,781,545.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,267,000.00	466,491,407.03	74,775,592.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,205,100.00	203,740,682.00	28,464,418.00
210101	Үндсэн цалин	187,436,200.00	157,741,844.00	29,694,356.00
210102	Нэмэгдэл	44,768,900.00	32,158,689.00	12,610,211.00
210104	Урамшуулал	0	13,840,149.00	-13,840,149.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,347,800.00	26,811,307.32	4,536,492.68
210201	Тэтгэврийн даатгал	22,059,500.00	18,663,825.98	3,395,674.02
210202	Тэтгэмжийн даатгал	2,322,100.00	2,100,863.41	221,236.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,857,600.00	1,657,169.26	200,430.74
210204	Ажилгүйдлийн даатгал	464,500.00	397,256.83	67,243.17
210205	Эрүүл мэндийн даатгал	4,644,100.00	3,992,191.84	651,908.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,880,400.00	49,401,975.00	1,478,425.00
210301	Гэрэл, цахилгаан	9,187,800.00	13,868,071.00	-4,680,271.00
210302	Түлш, халаалт	41,492,600.00	35,533,904.00	5,958,696.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	0	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,210,400.00	53,210,399.71	0.29
210401	Бичиг хэрэг	1,198,800.00	1,198,800.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	9,611,600.00	9,611,600.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,200,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	41,200,000.00	41,199,999.71	0.29
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	2,988,700.00	2,988,700.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,988,700.00	2,988,700.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	69,365,400.00	69,186,306.00	179,094.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	68,198,900.00	68,113,021.00	85,879.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	309,700.00	254,025.00	55,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	393,800.00	356,260.00	37,540.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	143,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,769,200.00	59,652,037.00	40,117,163.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,769,200.00	59,652,037.00	40,117,163.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,852,700.00	10,846,747.00	5,953.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,852,700.00	10,846,747.00	5,953.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,852,700.00	9,852,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	994,047.00	5,953.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,000,000.00	0	50,000,000.00
223001	Бусад хөрөнгө	50,000,000.00	0	50,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	602,119,700.00	553,520,300.00	48,599,400.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	567,297,300.00	553,520,300.00	13,777,000.00
320001	Орон нутгийн төсвөөс	567,297,300.00	553,520,300.00	13,777,000.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	34,822,400.00	0	34,822,400.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	34,822,400.00	0	34,822,400.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,643,296.00	95,397,817.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,643,296.00	95,397,817.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,768,435.00	95,397,817.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,809,378.00
210402	Тээвэр, шатахуун		1,809,378.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,067,498.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,067,498.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,700,937.00	93,588,439.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,570,937.00	93,588,439.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,874,861.00	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,874,861.00	00.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	8,874,861.00	00.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,643,296.00	95,397,817.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,643,296.00	95,397,817.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,707,096.00	6,507,602.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,936,200.00	88,890,215.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь төр-эдийн засаг, нийгмийн бодлогын үйл ажиллагаа явуулах чиглэлтэй, төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, төрийн захиргааны ажлыг тогтвортой, чанартай, стандартын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 оныг “Ногоон хөгжил-Баялаг бүтээгчдийг дэмжих жил” болгон зарлаж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 5 км урттай түймрийн халз зурвас татах ажлыг гүйцэтгэн, 13 урамшуулалт морин эргүүл, 8 байгаль хамгаалагч, 43 ойн нөхөрлөлийн гишүүдийг хяналтаар ажиллуулж, тайлант онд 78 га-д ойжуулалт хийжээ.

“Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих зэрэг ажлын хүрээнд засмал зам дагуу 5 нэр төрлийн 130 орчим ширхэг мод тарьсан байна.

Баялаг бүтээгчдийг дэмжих ажлын хүрээнд аймагт 4 удаагийн үзэсгэлэн худалдаа, суманд 3 удаагийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, ажилласан байна.

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 11 зорилт, 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгуулан ажиллаж, 90 хувиар хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2013 онд хэвлэгдсэн ба шинээр гарсан хууль тогтоомж заавар журмаар баяжуулан хэрэглэж байна. СТСХ-с нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нэгдсэн журмаар боловсруулж өгөх чиглэл өгсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 794,954.4 мянган төгрөгөөр буюу 1,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,000.0	2,078.6	78.6
Бараа материал	67,706.4	71,769.4	4,063.0
Үндсэн хөрөнгө	1,208,012.4	1,998,825.2	790,812.8
Нийт хөрөнгө	1,277,718.8	2,072,673.2	794,954.4
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,277,718.8	2,072,673.2	794,954.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,277,718.8	2,072,673.2	794,954.4

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны өөрчлөлтөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

Бараа материал дансны үлдэгдэл 71,769.4 мянган төгрөг болж, 4,063.0 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын дансанд байгаль орчны нөхөн сэргээлтийн зардлаас хийсэн 2022, 2023 онд ашиглах Ойн менежмент төлөвлөгөө 3,000,0 мянган төгрөг, Бэлчээрийн мэрэгч болон ойн хөнөөлт шавжийн судалгаа 3,000,0 мянган төгрөг, Цогт өндөр багийн байр тохижуулахад иргэдийн хандив 1,660,0 мянган төгрөгийн орлогыг бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,998,825.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 790,812.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нийт 991,977.2 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэж, аймаг, сумын ИТХ-ын шийдвэрээр, нийт 80,436.5 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Эздийн өмч 2,072,673.2 мянган төгрөг болж 794,954.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 604,649.9 мянган төгрөг, нийт зарлагыг 604,649.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 19,142.6 мянган төгрөгөөр бууруулж, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолоор 585,507.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсөв захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй ба Ковид-19 хөл хорио цуцлагдаж, бэлэн байдлын зэрэг буурч, үйл ажиллагаа энгийн горимд шилжсэнтэй холбоотойгоор төсвийн хүрэлцээ багассанаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 16,612.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот тогтоолоор 602,119.7 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 602,119.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 553,520,3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 477,338.1 мянган төгрөг буюу 79,3 хувьтай байгаа нь батлагдсан зардлын төсвийг 48,599,4 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн, орон нутгийн хөрөнгийн зардал 50,000.0 мянган төгрөгийг тендер сонгон шалгаруулалт цуцлагдсанаас зарцуулаагүй болон цалин шимтгэлийн зардал орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан 28,464.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106/80101-үндсэн үйл ажиллагаа	289,485.2	250,602.6	38,882.6	86,6%
2	70106/80103-Гүйцэтгэх үйл ажиллагаа	68,198.9	67,889.6	309.3	99,5%
3	70106/80106-Баг хорооны үйл ажиллагаа	62,226.1	59,125.7	3,100.4	95%
4,	70106/80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	10,852.7	10,846.8	5,9	99%
5	70106/80918 –Бусад	50,000.0		50,000.0	
6	70106/81102 –Орон нутгийн нөөц	5,000.0	2,904.4	2,095.6	58%
7	70106/82801-Улсын баяр наадам	5,000.0	5,000.0		100%
8	71411/ 81701- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	70,156.8	39,769.0	30,387.8	56,6%
9	71411/82212- Хог хаягдал зайлуулах,хортон мэрэгч зайлуулах	41,200.0	41,200.0	0	100%
		602,119.7	477,338.1		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд Засгийн газраас усны хөнгөлөлт 6,909.6 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөцөөс халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 1,809.4 мянган төгрөг, Төв хөдөлмөр эрхлэлтийн сангаас ажлын байрны судалгааны зардалд 156.0 мянган төгрөг, ХАА-н ээлжит тооллого явуулах зардалд 8,704.5 мянган төгрөг, Постын орлого 30,330.5 мянган төгрөг, баяр наадмын түрээсийн орлого 940.0 мянган

төгрөг, Газрын дуудлага худалдааны орлого 38,384.1 мянган төгрөг, Цахим тендерийн орлого 938.0 мянган төгрөг, зочид буудлын орлого 120.0 мянган төгрөг, Баяр наадмын морины бай шагналд хандив 3,500.0 мянган төгрөг, Кат тракторын нүүрс ачсан хөлс 3,750.0 мянган төгрөг, нийт 95,397.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Нэмэлтийн харилцах данснаас Мал эмнэлгүүдийн шатахуунд 1,809.4 мянган төгрөг, ХАА-н тооллого судалгаанд нийт 8,560.2 мянган төгрөг, Сөгнөгөр Баянголын постын гэрээт ажилчдын цалин шимтгэл, машины сэлбэг, бусад урсгал зардалд нийт 33,195.1 мянган төгрөг, ажлын байрны судалгааны шатахууны үнэ 156.0 мянган төгрөг, Баяр наадмын морины бай шагналд 3,500.0 мянган төгрөг, тендерийн бичиг хэргийн зардалд 440.8 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлогоос компьютер принтер 8,614.7 мянган төгрөг, Орон нутгийн орлого газрын төлбөрт 27,609.4 мянган төгрөг, татварын бус орлогод 4,602.7 мянган төгрөг, усны орлогод 6,909.5 мянган төгрөг тус тус шилжүүлж, нийт зарлага 95,397.8 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106/ орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022-01-02-12-30	Төрийн үйлчилгээг хуулийн иргэдэд хүртээмжтэй хүргэж, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 92,5%	490,762.9	396.369.1
2	71411/ хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022-01-01-12-30	Хур хог хаягдлын орчны бохирдлыг цэвэрлэж цэвэр орчин бүрдүүлэх	Хур хог хаягдлыг булшилж, шинэ хогийн цэгийн байгууламжтай болсон	111,356.8	80.969.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 602,119.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,031.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,773.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын тендер сонгон шалгаруулалт цуцлагдсанаас 50,000.0 мянган төгрөгийг, орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан цалин шимтгэлийн зардал 28,464.4 мянган төгрөгөөр хэмнэгдэж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 76,182.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах 4 мэдээллийг хугацаа хороож мэдээлсэн ба байршуулбал зохих мэдээллийг бүрэн оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 төлбөрийн акт, 3 албан шаардлага өгөгдсөнийг 93 % хэрэгжүүлэн, ЗДТГ-ын даргын 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 06/72 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2021 оны 02 дугаар сарын 23-нд хорголжин тэжээл /50 кг/ нэг бүрийн үнэ 32,259.00 төгрөгөөр 279 ширхэг нийт 9,000.0 мянган төгрөгийн тэжээлийг орлого авч, борлуулаагүй үр ашиггүй хөрөнгө бэлтгэсэн зөрчилд албан шаардлага бичигдсэн боловч орон нутагт зах зээлд борлогдож байгаа үнэ нь дансны үнээс доогуур тул борлогдоогүй үлдэгдэлтэй хэвээр байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	6,397.9	2	6397.9	100
Албан шаардлага	3	123,852.2	2	114,852.2	92,7
Зөвлөмж	0				
Нийт дүн	5	130,250.1	4	121,250.1	93,0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Батсүмбэр сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар хөрөнгийн тооллого, тооцоо бодолтод анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 121,672.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 121,672.1 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, үндсэн хөрөнгийн болон бараа материалын тайлангийн тодруулгаас 12,500.3 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тайлант оны элэгдлийн зардлаас 3,299.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгсэл дансанд шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 105,872.7 мянган төгрөгийн хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг буруу ангилан бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 9,600.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 600.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 9,000.0 мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Төлбөрийн акт

Шатах тослох материал дансны үлдэгдэл 600.0 мянган төгрөгийн шатахууны талоны үлдэгдлийг тулгахад тооллогын комисс нь бараа материалын тооллогын бүртгэл хөтлөөгүй нь тухайн хөрөнгө оршин буй эсэхийг тулган шалгах боломжгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", 73 дугаар зүйлийн 73.2-д "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

ЗДТГ-ын 2021 оны 02 дугаар сарын 23-нд бэлтгэсэн, нийт 9,000.0 мянган төгрөгийн үнэтэй 279 шуудай хорголжин тэжээлийг борлуулаагүй үр ашиггүй хөрөнгө бэлтгэсэн зөрчилд албан шаардлага бичигдсэн боловч орон нутагт зах зээлд борлогдож байгаа үнэ нь дансны үнээс доогуур тул борлогдоогүй үлдэгдэлтэй хэвээр байгаа зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй байх” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн тооллого тооцоо бодолттой холбоотой асуудал

Илрүүлэлт:

ЗДТГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/33 дугаар тушаалаар байгууллагын өмч хөрөнгийг тоолох комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй ХАА-н мэргэжилтэн Н.Төмөртуяагаар ахлуулан томилсон байна. Тооллогын комисс нь актлах хөрөнгийн болон үндсэн хөрөнгийн тооллогын жагсаалтыг санхүүд хүлээлгэн өгсөн ба бараа материалын үлдэгдлийг тоолсон тооллогын бүртгэл байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Хөрөнгийн тооллого, тооцоо бодолтыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж, өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн санхүүд хүлээлгэн өгч хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээлли йг тусгахгүй орхигдуул сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй орлого зөрүүтэй	1	15,799.4			1	15,799.4	1	15,799.4				
Буруу ангилан бүртгэсэн	1	105,872.7			1	105,872.7	1	105,872.7				
Дүн	2	121,672.1			2	121,672.1	2	121,672.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Шатахууны талоны үлдэгдэл оршин байсан нь нотлогдоогүй	1	600.0	1	600.0								
Хорголжин тэжээл удаан хугацаагаар хадгалах	1	9,000.0			1	9,000.0						
Бараа материалын тооллогын бүртгэл байхгүй	1						1					
Дүн					1	9,000.0	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0					0	0